

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Амармэнд

Утас: 70453799, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.ОДОНХҮҮ ТАНАА

0026.0205 № 984-2026 /119 /НВ-СДВ-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050680

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,603,800.00	8,692,775.19
33	АВЛАГА		5,088,975.19
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		5,088,975.19
35	БАРАА МАТЕРИАЛ	3,603,800.00	3,603,800.00
354	Хангамжийн материал	3,603,800.00	3,603,800.00
3542	Аж ахуйн материал	673,500.00	673,500.00
3547	Бусад хангамжийн материал	2,930,300.00	2,930,300.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	41,355,588.17	31,066,010.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	41,355,588.17	31,066,010.22
392	Биет хөрөнгө	40,991,977.05	28,723,232.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,000,000.00	24,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,333,333.34	-9,333,333.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24,019,800.00	27,199,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,519,841.83	-21,002,548.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,417,160.00	11,406,110.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-591,807.78	-3,546,696.16
393	Биет бус хөрөнгө	363,611.12	2,342,777.82
39301	Програм хангамж	385,000.00	2,885,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-21,388.88	-542,222.18
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	44,959,388.17	39,758,785.41
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	260,485.00	11,718,884.32
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	260,485.00	11,718,884.32
413	Өглөг	260,485.00	11,718,884.32
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	260,485.00	9,155,128.32
4136	Бусад өглөг	0.00	324,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	324,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	2,239,756.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	44,698,903.17	28,039,901.09
51	Засгийн газрын хувь оролцоо	44,698,903.17	28,039,901.09
512	Хуримтлагдсан үр дүн	44,698,903.17	28,039,901.09
5121	Өмнөх үеийн үр дүн	44,698,903.17	44,698,903.17
5122	Тайлант үеийн үр дүн		-16,659,002.08
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	44,959,388.17	39,758,785.41

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	474,756,760.00	496,116,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,778,160.00	
120	Нийтлэг татварын бус орлого	32,778,160.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	32,778,160.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,978,600.00	496,116,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	441,978,600.00	494,116,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	441,978,600.00	494,116,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	452,144,196.76	512,775,502.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,144,196.76	512,775,502.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,776,099.76	492,590,604.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,651,236.91	403,592,130.31
210101	Үндсэн цалин	169,147,571.53	185,374,920.02
210102	Нэмэгдэл	127,478,707.38	179,787,320.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,141,000.00	18,773,000.00
210104	Урамшуулал	19,883,958.00	19,656,889.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,574,025.71	50,708,083.67
210201	Тэтгэврийн даатгал	27,247,110.12	35,782,667.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,205,542.37	3,731,354.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,644,043.19	1,865,676.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,095,466.01	1,865,675.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,381,864.02	7,462,709.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,500,000.00
210304	Байрны түрээс		2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,439,361.38	6,763,263.00
210401	Бичиг хэрэг	950,100.00	31,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,903,400.00	2,763,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,884,721.38	2,008,963.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,701,140.00	1,959,400.00
210408	Бараа материал акталсны зардал	3,000,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,192,500.00	1,043,700.00
210604	Урсгал засвар	11,192,500.00	1,043,700.00
2107	Томилолт, зочны зардал	9,398,000.00	4,806,000.00
210702	Дотоод албан томилолт	9,398,000.00	4,806,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,183,379.00	1,009,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,379.00	

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	89,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,337,596.76	22,168,427.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	930,000.00	2,210,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,407,596.76	19,958,427.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,368,097.00	20,184,897.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,417,796.00	1,700,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,677,796.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,740,000.00	1,700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		18,484,897.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		18,484,897.15
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,950,301.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,950,301.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	22,612,563.24	-16,659,002.08
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	22,612,563.24	-16,659,002.08

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	441,978,600.00	496,116,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,978,600.00	496,116,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	441,978,600.00	494,116,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	441,978,600.00	494,116,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	441,978,600.00	488,947,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,978,600.00	488,947,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,610,503.00	468,762,752.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,651,236.91	401,612,859.31
210101	Үндсэн цалин	169,147,571.53	178,046,188.83
210102	Нэмэгдэл	127,478,707.38	185,136,780.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,141,000.00	18,773,000.00
210104	Урамшуулал	19,883,958.00	19,656,889.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,574,025.71	46,641,930.54
210201	Тэтгэврийн даатгал	27,247,110.12	31,716,514.07
210202	Тэтгэмжийн даатгал	3,205,542.37	3,731,354.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,644,043.19	1,865,676.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,095,466.01	1,865,675.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,381,864.02	7,462,709.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,500,000.00
210304	Байрны түрээс		2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,691,361.38	6,763,263.00
210401	Бичиг хэрэг	950,100.00	31,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,903,400.00	2,763,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,136,721.38	2,008,963.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,701,140.00	1,959,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,182,500.00	1,043,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,760,000.00	
210604	Урсгал засвар	4,422,500.00	1,043,700.00
2107	Томилолт, зочны зардал	9,398,000.00	4,806,000.00
210702	Дотоод албан томилолт	9,398,000.00	4,806,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,183,379.00	3,185,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,379.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	2,589,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	930,000.00	2,210,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	930,000.00	2,210,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,368,097.00	20,184,897.15

2132	Бусад урсгал шилжүүлэг	32,417,796.00	1,700,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,677,796.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,740,000.00	1,700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		18,484,897.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		18,484,897.15
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,950,301.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,950,301.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		7,168,850.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		7,168,850.00
	Дотоод эх үүсвэрээр		7,168,850.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		7,168,850.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-7,168,850.00

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			44,698,903.17	44,698,903.17
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			44,698,903.17	44,698,903.17
9	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			44,698,903.17	44,698,903.17
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
16	Тайлант үеийн үр дүн			-16,659,002.08	-16,659,002.08
16	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			28,039,901.09	28,039,901.09

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	494,116,500.00	475,631,602.85	18,484,897.15	96.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	494,116,500.00	468,462,752.85	25,653,747.15	94.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	492,116,500.00	466,762,752.85	25,353,747.15	94.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	401,753,800.00	401,612,859.31	140,940.69	100.0
210101	Үндсэн цалин	174,522,100.00	178,046,188.83	(3,524,088.83)	102.0
210102	Нэмэгдэл	201,586,400.00	185,136,780.98	16,449,619.02	91.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,160,000.00	18,773,000.00	(7,613,000.00)	168.2
210104	Урамшуулал	14,485,300.00	19,656,889.50	(5,171,589.50)	135.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,219,300.00	46,641,930.54	3,577,369.46	92.9
210201	Тэтгэврийн даатгал	34,149,100.00	31,716,514.07	2,432,585.93	92.9
210202	Тэтгэмжийн даатгал	4,017,500.00	3,731,354.60	286,145.40	92.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,008,800.00	1,865,676.81	143,123.19	92.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,008,800.00	1,865,675.86	143,124.14	92.9
210205	Эрүүл мэндийн даатгал	8,035,100.00	7,462,709.20	572,390.80	92.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,000,000.00	2,500,000.00	500,000.00	83.3
210304	Байрны түрээс	3,000,000.00	2,500,000.00	500,000.00	83.3
2104	Хангамж, бараа материалын зардал	10,868,500.00	6,763,263.00	4,105,237.00	62.2
210401	Бичиг хэрэг	1,400,000.00	31,400.00	1,368,600.00	2.2
210402	Тээвэр, шатахуун	2,765,000.00	2,763,500.00	1,500.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,556,900.00	2,008,963.00	1,547,937.00	56.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,146,600.00	1,959,400.00	1,187,200.00	62.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,950,000.00	1,043,700.00	13,906,300.00	7.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,550,000.00		5,550,000.00	
210602	Тавилга	4,200,000.00		4,200,000.00	
210604	Урсгал засвар	5,200,000.00	1,043,700.00	4,156,300.00	20.1
2107	Томилолт, зочны зардал	4,995,000.00	4,806,000.00	189,000.00	96.2
210702	Дотоод албан томилолт	4,995,000.00	4,806,000.00	189,000.00	96.2

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,392,400.00	3,185,000.00	2,207,400.00	59.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00		600,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00		100.0
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00		100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,500.00		183,500.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	22,000.00	11,000.00	66.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,001,900.00	2,589,000.00	1,412,900.00	64.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	937,500.00	210,000.00	727,500.00	22.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	937,500.00	210,000.00	727,500.00	22.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		7,168,850.00	(7,168,850.00)	
	Дотоод эх үүсвэрээр ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		7,168,850.00	(7,168,850.00)	
1	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		475,631,602.85	(475,631,602.85)	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		475,631,602.85	(475,631,602.85)	
132001	Орон нутгийн төсвөөс		475,631,602.85	(475,631,602.85)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,000,000.00	-2,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,000,000.00	-2,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,000,000.00	-2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,000,000.00	-2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,000,000.00	-2,000,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,000,000.00	-2,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,000,000.00	-2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		2,000,000.00	-2,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь төсвийн хөрөнгийг нийгмийн нийтлэг эрх ашгийн төлөө хууль тогтоомжийн хүрээнд үр ашигтай зарцуулдаг байдлыг хангуулах үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,200.6 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Авлага		5,089.0	5,089.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	3,603.8	3,603.8	0.0
Үндсэн хөрөнгө	41,355.6	31,066.0	(10,289.6)
Нийт хөрөнгө	44,959.4	39,758.8	(5,200.6)
Өр төлбөр	260.5	11,718.9	11,458.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	44,698.9	28,039.9	(16,659.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	44,959.4	39,758.8	(5,200.6)

Авлага дансны үлдэгдэл 5,089.0 мянган төгрөг болж 5,089.0 мянган төгрөгөөр өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчаас ХХОАТ суутган тооцож татварын байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой үүссэн авлага байна.

Үндсэн хөрөнгийн данс нь үлдэгдэл 31,066.0 мянган төгрөг болж 10,289.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 3,179.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,988.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2,500.0 мянган төгрөгөөр санхүүгийн программ худалдан авсан, тайлант онд 19,958.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 11,718.9 мянган төгрөг болж 11,458.4 мянган төгрөгөөр өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчид олгох ХХОАТ-ын өглөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 28,039.9 мянган төгрөг болж 16,659.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 591,696.8 мянга, нийт зарлагыг 591,696.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 48,950.1 мянган төгрөгөөр бууруулан 542,746.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 48,630.2 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 494,116.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 475,631.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 475,631.6 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь зарим зардлын гүйлгээний эрх хязгаарласан болон 18,484.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70429-Санхүүгийн хяналт, дотоод аудит эрсдэлийн удирдлага 80101-Үйл ажиллагааны зардал	488,516.5	475,631.6	17,084.9	96.2%
2	70429-Санхүүгийн хяналт, дотоод аудит эрсдэлийн удирдлага, 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол	3,000.0	2,500.0	500.0	83.3%
3	70429-Санхүүгийн хяналт, дотоод аудит эрсдэлийн удирдлага, 80205-Мэдээлэл, сурталчилгааны зардал	600.0	0.0	600.0	
4	70429-Санхүүгийн хяналт, дотоод аудит эрсдэлийн удирдлага, 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2,000.0	1,700.0	300.0	85.0%
	Нийт	606,410.3	580,987.9	25,422.4	95.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/			
№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	2,500.0	Тайлант онд шинээр санхүүгийн CTS программ ашиглаж эхэлсэн
2	Унаа, хоолны зардал	18,773.0	2025 онд 18,773.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар	210.0	Сургалтын зардлаас тайлант онд 210.0 мянган төгрөгийн сургалтын төлбөр төлсөн байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	0.0	Хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зардал гараагүй байна.
7	Орон тоо	401,612.9	Тайлант онд 10 орон тоо ажиллахаар батлагдсанаас 9 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын нэмэлт нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,000.0 мянган төгрөгийн орлого хүлээн авч зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай бараа материал болон хөрөнгө худалдан авахад 15,466.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 452,404.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,524.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 510,535.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 5,105.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 4,084.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 379,545.7 мянган төгрөгийн 9 гүйлгээг хугацаа хоцроож, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 8,248.0 мянган төгрөгийн 8 шийдвэр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	1	8,248.0					1	8,248.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР 



2026 оны 02 сарын 04-ний өдөр